

Капекс Капитал ХХК-ийн ВХҮҮ-ийн бодлого, журам

Биржийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох төлөвлөгөө

Сарех биржийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээг хурдан бөгөөд үр дүнтэй авах, компанийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх боломжийг олгох зорилгоор Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан болно. Энэхүү төлөвлөгөө нь байгалийн давагдашгүй хүчин зүйл, системийн үйл ажиллагаанд саатал догогдол учирч болзошгүй нөхцөл байдлын үед бизнесийн үйл ажиллагааны эдийн засгийн алдагдлыг бууруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, биржийн урт хугацааны тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангахад чиглэнэ. Биржийн үйл ажиллагаанд эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед биржийн үйл ажиллагаа түр болон тодорхойгүй хугацаагаар зогсох болсон талаар мэдээллийг харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч зэрэг оролцогч талуудад учирч болох сөрөг нөлөөг хамгийн бага түвшинд байлгах зорилгоор хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хамрах хүрээг тодорхойлоод буй бөгөөд энэхүү төлөвлөгөөнд заасны дагуу зөв системтэйгээр, цаашид авч хэрэгжүүлэх ажлын дарааллыг ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар тухай бүрт биржийн бүхий л албан ёсны сувгуудаар хүргэн ажиллана.

Бирж бүртгэлээс хасагдаж, үйл ажиллагаа зогсоосон тохиолдолд авах арга хэмжээ

Сарех бирж СЗХ-ноос баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам”-ын дагуу аливаа эрсдэл учирсан тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй найдвартай үргэлжлүүлэх, харилцагчийн мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Бизнесийн Тасралтгүй Үйл Ажиллагааны Төлөвлөгөө болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлаад буй. Энэхүү төлөвлөгөөгөөр онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдал үүссэн үед тасралтгүй байдлыг хангах, сэргээх арга хэмжээг зохион байгуулахад оршино. Төлөвлөгөөнд заасны дагуу тухайн нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэх захирлын тушаалаар төлөвлөгөөнд дурдсан бүтцээр ажлын хэсэг байгуулж уг нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг илрүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, холбогдох удирдлагад тайлагнах зэрэг шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.